



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/82

Жаргалант

**Хагас жилийн мал тооллого
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", 20 дугаар зүйлийн 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн А/319 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-өөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны хооронд явуулсугай.

2.2024 оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Шижирмөнх	Сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Б.Сумъяа	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд:	Б.Эрдэнэжаргал	ХАА-н тасгийн мэргэжилтэн
	О.Банхар	Мал эмнэлэгийн улсын хяналтын байцаагч
	Х.Оюунгэрэл	Татварын улсын байцаагч
	Х.Амарбаясгалан	Баян-Өлзийт багийн дарга
	А.Уранчимэг	Ангирт багийн дарга
	Э.Бат-Орших	Онон багийн ИНХ-ын дарга
	Г.Оюунчимэг	Жаргалант багийн дарга
	Б.Бямбасүх	Ард даатгалын төлөөлөл

3.Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, багийн ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д үүрэг болгосугай.

4.Хагас жилийн мал тооллогыг засаг захиргааны нэгжид зохион байгууллахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч тооллогыг нэгэн зэрэг хугацаанд нь эхлүүлж, чанартай зохион байгуулахад хяналт тавьж, тооллогын шивэлт, дүнг эцэслэн боловсруулж аймгийн тооллогын ажлын хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 15-нд мэдээлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Сумъяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.ДАВААЖАРГАЛ



232501186

100/1000000

